



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2025/041/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2025 он</p>	<p>Өмнөговь дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: bolormaaja@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 70533552 Цахим хаяг: jargale@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.25 № 97
танай _____-ны № _____-т

ХАНБОГД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Ө.УУГАНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант хугацаанд орон нутгийн нөөц сангаас 10,000.0 мянган төгрөг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар 3,000.0 мянган төгрөг зарцуулсан, тайланд тусгасан 16,414.1 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийж, тооцоо бодоогүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.6, 13.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгтэй нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, ангилал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хот, хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хотын төвлөрлийг сааруулах, төрийн албан хаагчид орон нутагт тогтвор, суурьшилтай ажиллах нөхцөлийг баталгаажуулах зорилгоор Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу нэг албан хаагчид 12,870.0 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

4625020274

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Досх

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Өмнөговь аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй "Нутгийн дэм" хөтөлбөрийн хүрээнд байгууллагын албан хаагчдыг хамруулан 18,213.4 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэн 84.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБЯАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,052,364.30	44,738,850.35
33	АВЛАГА	262,978.30	479,078.85
335	Бусад авлага	262,978.30	479,078.85
3351	Байгууллагаас авах авлага	262,978.30	479,078.85
34	УРЬДЧИЛГАА	-	42,590,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	42,590,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,789,386.00	1,669,771.50
354	Хангамжийн материал	4,789,386.00	1,669,771.50
35410	Бичиг хэргийн материал	77,000.00	-
35420	Аж ахуйн материал	4,712,386.00	1,669,771.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,569,519.32	11,423,394.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,569,519.32	11,423,394.64
392	Биет хөрөнгө	7,569,519.32	11,423,394.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,950,000.00	59,950,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(59,950,000.00)	(59,950,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	19,595,450.00	23,723,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(15,965,930.05)	(17,378,905.09)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,741,300.00	18,125,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,046,300.27)	(13,046,300.27)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,450,000.00	2,450,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,205,000.36)	(2,450,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,621,883.62	56,162,244.99
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,621,883.63	56,069,204.72
51	Засгийн газрын хувь оролцоо	12,621,883.63	56,069,204.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,658,512.00	9,658,512.00
51101	Өмч: - төрийн	9,658,512.00	9,658,512.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,963,371.63	46,410,692.72
51210	Өмнөх үеийн үр дүн	2,963,371.63	2,963,371.63
51220	Тайлант үеийн үр дүн	-	43,447,321.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,621,883.63	56,069,204.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	333,036,376.00	493,740,934.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	720,000.00	10,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	720,000.00	10,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	332,316,376.00	493,730,934.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,445,076.00	18,213,434.00

**Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,595,076.00	18,213,434.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,850,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	313,871,300.00	475,517,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	313,871,300.00	475,517,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	333,215,066.46	451,352,748.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	333,215,066.46	451,352,748.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	254,214,822.57	361,773,971.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	90,753,858.03	145,576,710.82
210101	Үндсэн цалин	57,218,847.67	73,838,135.56
210102	Нэмэгдэл	21,332,910.36	59,514,563.27
210104	Урамшуулал	12,202,100.00	12,224,011.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,010,657.78	18,362,299.64
210201	Тэтгэврийн даатгал	6,782,207.84	12,500,781.30
210202	Тэтгэмжийн даатгал	834,728.82	1,473,326.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	638,325.43	978,444.29
210204	Ажилгүйдлийн даатгал	159,582.09	564,659.61
210205	Эрүүл мэндийн даатгал	1,595,813.60	2,845,087.84
2104	Хангамж, бараа материалын зардал	26,710,000.00	50,038,928.00
210401	Бичиг хэрэг	2,900,000.00	5,720,130.00
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.00	35,835,305.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,810,000.00	4,221,703.00
210408	Бараа материал акталсны зардал	-	4,261,790.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	14,341,500.00
210604	Урсгал засвар	-	14,341,500.00
2107	Томилолт, зочны зардал	512,000.00	1,190,000.00
210702	Дотоод албан томилолт	512,000.00	1,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,844,090.00	69,558,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,844,090.00	69,558,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,384,216.76	62,706,432.68
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,759,370.00	52,151,148.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	8,897,310.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,624,846.76	1,657,974.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,000,243.89	89,578,776.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,705,076.00	19,398,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,705,076.00	19,398,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	68,905,141.07
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	68,905,141.07
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	59,295,167.89	1,275,235.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,295,167.89	-
213404	Хөрөнгийн	-	1,275,235.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(178,690.46)	43,447,321.09
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(178,690.46)	43,447,321.09

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	332,316,376.00	493,740,934.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	10,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	10,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	10,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	332,316,376.00	493,730,934.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,445,076.00	18,213,434.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,595,076.00	18,213,434.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	313,871,300.00	475,517,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	313,871,300.00	475,517,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	332,316,376.00	488,229,084.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,316,376.00	488,229,084.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	253,316,132.11	398,650,307.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	91,016,836.33	145,782,811.47
210101	Үндсэн цалин	57,224,026.96	75,103,371.43
210102	Нэмэгдэл	21,332,910.35	58,455,428.05
210104	Урамшуулал	12,459,899.02	12,224,011.99
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,973,835.78	18,362,299.54
210201	Тэтгэврийн даатгал	6,782,207.84	12,500,781.30
210202	Тэтгэмжийн даатгал	797,906.82	1,473,326.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	638,325.43	978,444.29
210204	Ажилгүйдлийн даатгал	159,582.09	564,659.61
210205	Эрүүл мэндийн даатгал	1,595,813.60	2,845,087.74
2104	Хангамж, бараа материалын зардал	26,710,000.00	45,777,138.00
210401	Бичиг хэрэг	2,900,000.00	5,720,130.00
210402	Тээвэр, шатахуун	21,000,000.00	35,835,305.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,810,000.00	4,221,703.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	14,341,500.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	14,341,500.00
2107	Томилолт, зочны зардал	512,000.00	1,190,000.00
210702	Дотоод албан томилолт	512,000.00	1,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	96,844,090.00	112,148,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96,844,090.00	112,148,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,759,370.00	61,048,458.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,759,370.00	52,151,148.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,000,000.00	8,897,310.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,000,243.89	89,578,776.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,705,076.00	19,398,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,705,076.00	19,398,400.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	59,295,167.89	70,180,376.99
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	59,295,167.89	68,905,141.07
213404	Хөрөнгийн	-	1,275,235.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	5,511,850.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	5,511,850.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	5,511,850.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	5,511,850.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,511,850.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	(5,511,850.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=

Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,658,512.00	2,963,371.63	12,621,883.63
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,658,512.00	2,963,371.63	12,621,883.63
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,658,512.00	2,963,371.63	12,621,883.63
Тайлант үеийн үр дүн	-	43,447,321.09	43,447,321.09
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,658,512.00	46,410,692.72	56,069,204.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,517,500.00	406,335,058.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,517,500.00	406,335,058.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	453,417,500.00	392,426,658.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,250,000.00	135,722,168.18
210101	Үндсэн цалин	88,200,000.00	75,103,371.43
210102	Нэмэгдэл	66,600,000.00	58,455,428.05
210104	Урамшуулал	4,450,000.00	2,163,368.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,966,500.00	16,974,744.75
210201	Тэтгэврийн даатгал	13,536,300.00	11,542,809.51
210202	Тэтгэмжийн даатгал	1,592,500.00	1,357,977.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,274,000.00	769,528.29
210204	Ажилгүйдлийн даатгал	1,378,700.00	455,157.16
210205	Эрүүл мэндийн даатгал	3,185,000.00	2,849,272.19
2104	Хангамж, бараа материалын зардал	47,596,100.00	45,777,138.00
210401	Бичиг хэрэг	5,800,000.00	5,720,130.00
210402	Тээвэр, шатахуун	36,000,000.00	35,835,305.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	856,300.00	-
210404	Ном, хэвлэл	900,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,039,800.00	4,221,703.00
2105	Нормативт зардал	150,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,000,000.00	19,853,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,000,000.00	5,511,850.00
210604	Урсгал засвар	23,000,000.00	14,341,500.00
2107	Томилолт, зочны зардал	2,324,900.00	1,190,000.00
210702	Дотоод албан томилолт	2,324,900.00	1,190,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	117,500,000.00	112,148,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,500,000.00	112,148,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,630,000.00	60,761,158.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,630,000.00	51,863,848.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,000,000.00	8,897,310.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,100,000.00	13,908,400.00

**Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

2132	Бусад урсгал шилжүүлэг	22,100,000.00	13,908,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,100,000.00	13,908,400.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	475,517,500.00	406,612,358.93
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	475,517,500.00	406,612,358.93
132001	Орон нутгийн төсвөөс	475,517,500.00	406,612,358.93
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5.1 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,938,198.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,938,198.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,448,198.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,060,643.29
210104	Урамшуулал	10,060,643.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,387,554.79
210201	Тэтгэврийн даатгал	957,971.79
210202	Тэтгэмжийн даатгал	115,349.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	208,916.00
210204	Ажилгүйдлийн даатгал	49,131.00
210205	Эрүүл мэндийн даатгал	56,187.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,490,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,490,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,490,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	18,213,434.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	18,213,434.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	18,213,434.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 86,544.2 мянган төгрөгийн 7 алдаа¹ илэрснээс аудитын явцад 86,544.2 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 6,611.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг зардлын санхүүжүүлэх эх үүсвэртэй тулган баталгаажуулахад 6,708.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн цалингийн зардлын дүнг өглөгийн тодруулга тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 2,557.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Тайлант оны эцэст орон нутгийн төсөвт 68,905.1 мянган төгрөгийг төвлөрүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулах бичилт хийгээгүй,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Бараа үйлчилгээний бусад зардлаас 1,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий акурель самбарыг үндсэн хөрөнгө дансны тавилга, аж ахуйн эд хогшил ангилалд бүртгэсэн,
- Тайлант онд 115.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг бүртгэлд тусгаагүй тайлагнасан,
- Тайлант онд 646.0 мянган төгрөгийн НДШ-ын авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан нь УСНББОУС 1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2 "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 86,544.2 мянган төгрөгөөр залруулав.

Аудитаар 112,075.8 мянган төгрөгийн 12 зөрчил² илэрсэнд 1 төлбөрийн акт, 5 албан шаардлага, 5 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт-1: Тайлант хугацаанд 12,000.0 мянган төгрөгийн гарын бэлэг худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.7-д "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу төлбөрийн акт тогтоох

3.2 Албан шаардлага

Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал:

Илрүүлэлт-1: Тайлант хугацаанд бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 295.8 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-2: Тамгын газрын бүтэц орон тоонд батлагдан ажиллаж байгаа ИТХ-ыг хариуцсан нягтлан бодогчид 3,000.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Авлигын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно", 7.1.7-д "албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Илрүүлэлт-3 Тайлант хугацаанд төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардалд 70,000.0 мянган төгрөг батлан зарцуулан ажилласан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын хавсралтад заасан Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишигт заасантай нийцээгүй байна.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт-4: Ханбогд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн утасны төлбөр 1,600.0 мянган төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 25 дугаар зүйлийн 25.10 "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно", Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 152 дугаар тоот тушаалаар батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын 2 дах хэсгийн 9 "гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан олгосон хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулах уг хөрөнгө олгогдоогүй байхад урьдчилан зардал гаргахыг хориглоно" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Илрүүлэлт-5: Тайлант хугацаанд орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас ИТХ-ын нарийн бичгийн даргад 5,400.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг олгосон,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Авлигын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 "Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглоноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно", 7.1.7 "албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-6: Тайланд тусгасан 16,414.1 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.2-д "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Илрүүлэлт-7 Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг бүрэн байршуулаагүй, 171 мэдээлэл байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсанд алдаа зөрчлийг давтан гаргахгүй албан шаардлага хүргүүлэв.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.7-д "байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Дээрх зөрчлүүдэд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын дагуу албан шаардлага хүргүүлэв

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Тайлант хугацаанд 1,190.0 мянган төгрөгийн дотоод албан томилолт олгохдоо томилолтын хуудсыг томилолтоор ажиллуулсан байгууллага, байгууллагын дарга бүрэн бөглөж, баталгаажуулаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар хавсралтад заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогын комиссын ажлын үр дүнг сайжруулан, хөрөнгийн хяналт, хадгалалт, хамгаалалтыг дээшлүүлэн ажиллах,

Илрүүлэлт-2: Тайлант хугацаанд орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 1 иргэнд дэмжлэг хүссэн нотлох баримтгүйгээр 3,000.0 мянган төгрөгийн эмчилгээний дэмжлэг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д заасныг хэрэгжүүлэн анхан шатны баримтыг бүрэн бөглөж хэвших,

Илрүүлэлт-3: Тайлант хугацаанд бусад ангилагдаагүй нөөц хөрөнгийн зардлаас 42,590.0 мянган төгрөгийн 3 удаагийн сургалт зохион байгуулах ажлын гэрээний хэрэгжилт хангагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Ханбогд сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2024/03 тоот гэрээний 1.5 дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулан ажиллах, гэрээний хэрэгжилтийг хангаж, холбогдох тайланг ирүүлэн ажиллах,

Илрүүлэлт-4: Үндсэн хөрөнгийн дансанд 32 нэр төрлийн 5 ширхэг ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөггүй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: УСНББОУС-17, Холбогдох хууль, журам хэрэгжүүлж ажиллах,

Илрүүлэлт-5 Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.4-д "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган цахим дэлгүүрээс худалдан авалт хийж хэвших,

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн гүйлгээний тайлан дахь биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 6,611.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	6,611.8			1	6,611.8	1	6,611.8	-	-	-	-
2	Төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг зардлын санхүүжүүлэх эх үүсвэртэй тулган баталгаажуулахад 6,708.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	6,708.0			1	6,708.0	1	6,708.0				
3	Мөнгөн гүйлгээний тайлангийн цалингийн зардлын дүнг өглөгийн тодруулга тайлангийн уг зардалтай тулган баталгаажуулахад 2,557.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	2,557.4			1	2,557.4	1	2,557.4				
4	Тайлант оны эцэст орон нутгийн төсөвт 68,905.1 мянган төгрөгийг төвлөрүүлэхдээ төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулах бичилт хийгээгүй	1	68,905.1			1	68,905.1	1	68,905.1				
5	бараа үйлчилгээний бусад зардлаас 1,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий акурель самбарыг үндсэн хөрөнгө дансны тавилга, аж ахуйн эд хогшил ангилалд бүртгэсэн	1	1,000.0			1	1,000.0	1	1,000.0				
6	Тайлант онд 115.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг бүртгэлд тусгаагүй тайлагнасан	1	115.8			1	115.8	1	115.8				
7	Тайлант онд 646.0 мянган төгрөгийн НДШ-ын авлагыг бүртгэлд тусгаагүй тайлагнасан	1	646.0			1	646.0	1	646.0				
	Дүн	7	86,544.2	-	-	7	86,544.2	7	86,544.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд 1,190.0 мянган төгрөгийн дотоод албан томилолт олгохдоо томилолтын хуудсыг томилолтоор ажиллуулсан байгууллага, байгууллагын дарга бүрэн бөглөж, баталгаажуулаагүй	1	1,190.0					1	1,190.0				
2	Тайлант хугацаанд орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 1 иргэнд дэмжлэг хүссэн нотлох баримтгүйгээр 3,000.0 мянган төгрөгийн эмчилгээний дэмжлэг олгосон	1	3,000.0					1	3,000.0				
3	Тайлант хугацаанд бусад ангилагдаагүй нөөц хөрөнгийн зардлаас 42,590.0 мянган төгрөгийн 3 удаагийн сургалт зохион байгуулах ажлын гэрээний хэрэгжилт хангагдаагүй	1	42,590.0					1	42,590.0				
4	Үндсэн хөрөнгийн дансанд 32 нэр төрлийн 5 ширхэг ашиглалтын хугацаа дууссан үлдэх өртөггүй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна	1	-					1	-				
5	Тайлант хугацаанд бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 295.8 мянган төгрөгийн шатахуун худалдан авч зарцуулсан байна	1	295.8										
6	Ханбогд сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн утасны төлбөр 1,600.0 мянган төгрөгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас төлсөн	1	1,600.0			1							
7	Тамгын газрын бүтэц орон тоонд батлагдан ажиллаж байгаа ИТХ-ыг хариуцсан нягтлан бодогчид 3,000.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг олгож төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	1	3,000.0			1		3,000.0					

Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

8	Тайлант хугацаанд орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас ИТХ-ын нарийн бичгийн даргад 5,400.0 мянган төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэгийг олгосон	1	5,400.0				5,400.0					
9	Тайлант хугацаанд төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардалд 70,000.0 мянган төгрөг батлан зарцуулан ажилласан	1	43,000.0			1	43,000.0					
10	Тайланд тусгасан 16,414.1 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй	1	-			1	-					
Дүн		10	100,075.8	0	-	4	53,295.8	4	46,780.0			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант хугацаанд 12,000.0 мянган төгрөгийн гарын бэлэг худалдан авсан	1	12,000.0	1	12,000.0				
2	Тайлант хугацаанд төрийн болон орон төсвийн хөрөнгөөр бараа,ажил үйлчилгээ худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	-					1	-
3	Шилэн дансны нэгдсэн системд 171 мэдээлэл байршуулахаас 5 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан	1	-			1			
4	Шилэн дансны нэгдсэн системд байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.	1	-						
Дүн		4	12,000.0	1	12,000.0	1	-	1	-